

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

1. Үндсэн үйл ажиллагаа

Газрын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. “Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв”, “Учралт баяр өрхийн эрүүл мэндийн төв” зэрэг байгууллагуудын 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж байна.

“Аймгийн хөрөнгө оруулалтын ажил (Хүүхдийн паркийн тоглоомын худалдан авах ажиллагаа, суурилуулалтын ажил), “Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ, “Аймгийн Засаг даргын нөөц сан”, “Мөнхсүндрэл ӨЭМТөв”, “Баян-Өндөр сумын Хэсгийн ахлагчийн дэд хөтөлбөр”-ийн 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дуусгаж тус байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын 2025 оны II улирлын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд дотоод аудит хийж шилэн дансны хэрэгжилт 98.1%-тай дүгнэгдлээ.

Сангийн яаманд байгууллагын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны бичмэл тайлан болон хяналт шалгалттай холбоотой тоон тайланг 2025.07.09-ний өдөр цаасаар болон мэйлээр хүргүүлсэн.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР